

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО, ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ

Д.ЦЭРЭНПИЛ, ШУ-ны Доктор (Sc.D), профессор, МУИС-ийн ЭЗС-ийн Санхүүгийн тэнхмийн багш

Зах зээлийн эдийн засагт түүхэн шилжилт хийж буй манай улс орны өмнө олон бэрхшээлтэй асуудлууд тулгарч байгаагийн нэг нь Нийгмийн даатгалын тогтолцоо юм. Сүүлийн жилүүдэд даатгалын эрэлт хэрэгцээ улам өсөж байгаагийн хэрээр даатгалд хамрагдалтын хэмжээ, даатгалын хураамж, тэтгэвэр нөхөн олговор аль аль нь нэмэгдэж байна. Гэвч хүн амын гуравны нэгээс илүү нь ядуурч, аж ахуйн нэгж, байгууллагын олонхи нь төлбөрийн чадвар муутай өнөөгийн нөхцөлд ард иргэд даатгалын үүрэг ач холбогдлыг бүрэн гүйцэд ухаарахгүй байгаа зэргээс шалтгаалан Монголд даатгалын харилцаа зах зээлийн нөхцөлд байх тэр хэмжээнд төлөвшиж чадаагүй байна.

Судлаач уг бүтээлдээ Монголд нийгэм хангамж, даатгалын тогтолцооны хөгжлийг 3 үе шатанд хувааж үүсэж хөгжсөн түүхт, нийгэм, эдийн засгийн үүрэг ач холбогдлыг онол практикийн үүднээс тодорхойлжээ.

Мөн эрүүл мэндийн даатгалын тогтолцоог бий болгосноор нийгмийн даатгалын хөгжилд болон эрүүлийг хамгаалах байгууллагад санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгоход үнэтэй хувь нэмэр болсныг энд дурдсан байна.

Өнөөгийн нөхцөлд Монголын ниймийн даатгалын тогтоцооны шинэчлэлтийн үр дүнд гарсан ололт амжилтыг энд харуулж алдаа дутагдалд судлаачийн үнэлэлт дүгнэлт өгч бодлогын зөвлөмж, саналуудыг тусган толилууллаа.

ОРШИЛ

Нийгэм, эдийн засгийн янз бүрийн чиг баримжаа, хөгжлийн харилцан адилгүй түвшинд байгаа улс орнуудын нэг нийтлэг жишиг нь байгалийн элдэв сүйрэл, гамшиг, дайн дажны аюулт уршиг, эдийн засгийн хүчтэй хямралын улмаас хүн ам ядуурч хоосрох, амьдрал доройтоход хүний төлөө анхаарал, халамж бүх нийтийн үйлс байх ёстой гэсэн нэгдсэн чиг баримтлалын дор түүнийг арилгахад чиглэгдсэн төрөл бүрийн арга хэмжээг төр, засаг авч явуулж байдагт оршино.

Хүн төрөлхтөн аюулгүй байдлаа хамгаалах, амьжиргааны хэрэгцээгээ сахин хангах үүднээс янз бүрийн арга хэрэглэдгийн дотор нийгмийн хамгаалал, нийгмийн даатгал нэн чухал байрыг эзэлдэг.

Эдгээр нь:

- Нийгмийн баталгаат байдлын хөтөлбөрийг баталгаажуулсан төрийн хууль тогтоомжоор; энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд иргэдэд халамж, үйлчилгээ, мөнгөн тусламж үзүүлэхэд тодорхой хэмжээний санхүүгийн нөөц зориулагддагаар хэрэгждэг.

Нийгмийн даатгал бол хуулинд заасан тодорхой шалтгааны улмаас хөдөлмөрлөж цалин авдаггүй хүмүүсийн материаллаг хангамжинд зориулагдах мөнгөн хөрөнгийн санг бүрдүүлж ашиглахтай холбоотой санхүүгийн харилцаа, үйл явцыг өөртөө агуулж байдаг. Түүний гол зорилго нь ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх, өндөр настан, шалтгаантайгаар ажиллах чадваргүй болсон хүмүүсийн эрүүл мэнд болон аж байдалд материаллаг туслалцаа дэмжлэг үзүүлэх, амьдралын баталгааг найдвартай хангах явдал юм.

МОНГОЛД НИЙГМИЙН ХАНГАМЖ, ДААТГАЛ ХӨГЖСӨН ТҮҮХЭЭС

Монгол улсын нийгэм хангамжийн түүх өнө эртнээс уламжлагдан өвгөд хөгшид, өнчин дорд, ядуу зүдүү иргэдийг асран тэтгэх ажлыг төр зохицуулж байсан түүхэн замнал 1921 оноос хойш эдүгээ хүртэлх хугацаанд агуулга хэлбэрийн хувьд баяжин шинэчлэгдэж үндсээрээ өөрчлөгдөн улсын нийгмийн даатгал, нийгмийн халамжийн бие даасан тогтолцоо болж хөгжсөн юм.

Монголд нийгэм хангамж, даатгалын тогтолцооны хөгжлийг 3 үе шатанд хувааж байна.

Үүнд:

- а) 1925-1960 он нийгэм хангамжийн тогтолцоог бүрдүүлж бий болгосон ба нийгэм хангамжийн үйлчилгээнд чанарын дэвшил гарсан;
- б) 1960-1980 он нийгэм хангамж нь улс орны эдийн засаг, нийгмийн харилцааны хөгжилтэй уялдан зохион байгуулалтын хувьд бие даасан нэгдсэн тогтолцоо болж бүрэлдэн тогтсон;
- в) 1980-1990 он иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулж, нийгмийн даатгалын тогтолцоонд шилжих бэлтгэлийг хангах үе. Жишээ нь: 1990 онд “Тэтгэврийн сан”-г бий болгож, уг сангийн эх үүсвэр нь аж ахуйн нэгж байгууллагын эзэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс төлсөн (нийгмийн даатгалын шимтгэл), улсын төсвийн хөрөнгөөс бүрдэх болжээ. 1991 онд нийгмийн даатгалын тухай хууль батлагдаж шимтгэлийг төрийн мэдлийн төвлөрсөн тусгай санд төвлөрүүлэх болсон. 1991 онд Монгол улсын “Тэтгэмжийн тухай хууль” батлагдсан нь нийгмийн халамжийн эрх зүйн үндсийг тогтоолоо.

Зах зээлийн харилцаанд шилжихэд нийгмийн даатгалын тогтолцоог шинэчлэх зайлшгүй шаардлага тавигдлаа.

Нийгэм, эдийн засгийн хүрээнд хийсэн томоохон шинэчлэлтийн нэг нь зах зээлийн харилцааны жишигт нийцүүлэн нийгмийн даатгалын тогтолцоог өөрчилсөн явдал юм.

Өмчийн олон хэлбэр тогтож аж ахуйн янз бүрийн хэвшил ажиллах болсон нөхцөлд иргэдийн нийгмийн хамгааллын төлөө зөвхөн төр төдийгүй ААН байгууллагын эзэд, даатгуулагч, иргэд өөрсдөө хариуцлага хүлээх болсон.

Нийгмийн даатгал, хангамжийн тогтолцоог хөрөнгийн эх үүсвэрийн бүрдэлт, эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтын хэлбэр, арга механизмын хувьд үндсээр нь өөрчлөв. Үүний хууль эрх зүйн үндэс нь 1994 онд УИХ-аар нийгмийн даатгалын багц хуулийг батлан гаргаснаар бүрдэж 1995 оноос улс даяар мөрдүүлж эхэлсэн байна.

Ингэхдээ:

1. Өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ААН байгууллага болон түүнд ажиллагсад Нийгмийн даатгалын шимтгэл төлж, сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх;
2. Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, зохих болзол нөхцлийг хангасан тохиолдолд иргэд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрхээр хангагдах;
3. Даатгалын төрөл тус бүр өөрийн эх үүсвэр сангуудтай болж, сан байгуулах арга, хувь хэмжээ, зарцуулах журмыг хуульчлан тогтоосон;

4. Нийгмийн даатгал, нийгмийн хангамжийн урьд нь хавсарсан нэгдмэл хэлбэртэй байсныг зааглаж, нийгмийн даатгалын болон нийгмийн хангамжийн хоёр тогтолцоо болгон өөрчилж хөрөнгийн эх үүсвэр, зарцуулалтыг ялгаж, хуульчилсан зэрэг зарчмуудыг хатуу баримталж хийсэн.

Одоогийн шинэ тогтолцоогоор нийгмийн даатгал нь: тэтгэврийн даатгал, тэтгэмжийн даатгал, эрүүл мэндийн даатгал, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал, ажилгүйдлийн даатгал гэсэн таван төрөлтэй бөгөөд төрөл тус бүр нь өөрийн орлогын тогтоогдсон шимтгэлийн эх үүсвэртэй, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулна.

Нийгмийн даатгалын сангийн орлогын эх үүсвэр нь:

- Даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл;
- Ажил олгогчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл;
- Сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү;
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэнд оногдуулсан алданги болон бусад орлогоос бүрдэнэ.

Харин нийгмийн даатгалд жил бүр улсын төвлөрсөн төсвөөс тодорхой хэмжээний хөрөнгө, хуваариладгийн дотор тэтгэврийн даатгалын сангийн ихэнх хэсэг төсвөөс олгогддог. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага (1995-2001) (сая.төг)

	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2001/1995 өсөлт %
Орлого (шимтгэл)	20298.	2688	36232.	38178.		60361.	73886.	3.6
бүгд	6	3	2	1	43430	8	7	дахин
Төсвийн санхүүжилт	10230.	1024		14623.	16757.	19627.	20958.	
	7	4	9152.1	8	2	6	1	2 дахин
Нийт зарлага	24888.	3400	40377.	51947.	54459.	70539.	82017.	3.4
	4	9	5	8	6	1	6	дахин

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлагын 1995-2002 оны тайлан тэнцэл

Сүүлийн жилд нийгмийн даатгалын орлого сууриараа нэмэгдэж, санхүүгийн хувьд бэхжиж, зориулалтын зарлага нь өссөн байна. 2001 оныг 1995 онтой зэрэгцүүлэхэд орлого нь 3.6, зарлага нь 3.4 дахин нэмэгдсэн. Энэ хугацаанд улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө 2 дахин нэмэгдэв. Хэрэв 1995 онд нийгмийн даатгалын нийт хөрөнгийн 66 хувийг шимтгэлийн орлогоор бүрдүүлж байсан бол 2001 онд 77.9 хувийг бүрдүүлжээ.

Шимтгэлийн орлогын нийт дүн, хувийн жин нэмэгдэхийн хэрээр төсвөөс санхүүжүүлж байгаа хөрөнгийн эзлэх байр аажмаар буурах хандлагатай байна.

Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын өсөлт бүтцийг Хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2. Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын өсөлт, бүтэц (сая. төг %)

		1995		2001		2001/1995 харьцуулсан хувь
		Дүн	Хувь	Дүн	Хувь	
Даатгалын шимтгэл бүгд		20209.3	100	73886.7	100	3.7 дахин
Үүнээс	Тэтгэврийн	12623.4	62.5	44031.5	59.6	3.5 дахин
	Тэтгэмжийн	1468.7	7.3	4422.7	6	3.0 дахин
	ҮОМШӨ-ний	874.1	4.3	3113.5	4.2	3.6 дахин
	Ажилгүйдлийн	633.8	3.1	2253.7	3	3.6 дахин
	Эрүүл мэндийн даатгал	4609.3	22.8	20065.3	27.2	4.4 дахин

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангуудын орлого зарлагын 1995-2002 оны тайлан тэнцэл

Шимтгэлийн нийт орлогын 59.6 хувийг тэтгэврийн даатгалын шимтгэл, 27.2 хувийг эрүүл мэндийн даатгалын шимтгэл эзэлж байна. Бүх төрлийн даатгалын шимтгэлийн орлогын хэмжээ 1995-2001 оны хооронд 3.0-4.4 дахин нэмэгджээ.

Манай оронд эрүүл мэндийн даатгалын тогтолцоог бий болгосон нь нийгмийн даатгалын хөгжил болон эрүүлийг хамгаалах байгууллагын зарлагын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд эерэг чухал нөлөө үзүүлж байна..

Хүснэгт 3. Ажил олгогч, даатгуулагчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ

№	Даатгалын төрөл	Төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/	
		Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос	Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос
1	Тэтгэврийн даатгал	13.5	5.5
2	Тэтгэмжийн даатгал	1	1
3	ҮОМШӨ	1.0: 2.0: 3	
4	Ажилгүйдлийн даатгал	0.5	0.5
5	Эрүүл мэндийн даатгал	3	3
Дүн		19.0: 20: 21	10

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлагын 1995-2002 оны тайлан тэнцэл

Аж ахуйн нэгж, байгууллага 1995 оноос өмнө хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоосоо нийгмийн даатгалд 13.5 хувь шимтгэл төлж байсан бол таван төрлийн даатгалын шимтгэлийг нийтдээ 5.5-7.5 хувиар нэмэгдүүлж 19-21 хувь болгосон байна.

Даатгуулагч иргэд даатгалд шилжихээс өмнө шимтгэл төлдөггүй байсан бол мөн орлогоосоо нийтдээ 10 хувиар төлдөг журмыг шинээр тогтоосон. Төрийн

албан хаагчийн төлөх эрүүл мэндийн даатгалын хураамжийн 80 хувийг төр хариуцаж байна.

Мэргэжлийн сургуульд суралцагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин эрүүл мэндийн даатгалын хураамжаа өөрсдөө хариуцна. 16 хүртэл насны хүүхэд (ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа бол 18 нас хүртэлх), тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн, хүүхдээ 2 нас (ихэр бол 3 нас) хүртэл нь өсгөн бойжуулж буй эцэг, эх, нийгмийн халамжийн хуулиар тэтгэвэр авч буй иргэн, хугацаат цэргийн албан хаагчийн эрүүл мэндийн хураамжийг төр хариуцна.

Хорих ял эдэлж байгаа ялтны эрүүл мэндийн даатгалын хураамжийг хорих ял эдлүүлэх байгууллага нь хариуцна.

Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагч өргөн оролцох болсон бөгөөд сайн дураар даатгуулагч нь хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоосоо дараах хувь хэмжээгээр шимтгэл төлнө.

Үүнд:

- Тэтгэврийн даатгалд 9.5%
- Тэтгэмжийн даатгалд 1.0%
- ҮОМШӨ-ний даатгалд 1.0%

Эрүүл мэндийн даатгалд төлөх хураамжийг Засгийн газар жил бүр тогтооно. Эрүүл мэндийн даатгалд сайн дураар даатгуулагчийн төлөх сарын хураамжийн доод хэмжээг эрх бүхий байгууллагаас жил бүр тогтоож байна. Сайн дурын даатгуулагч нь 12 сараас доошгүй хугацаагаар хураамж төлсөн нөхцөлд эмчилгээний төлбөрийг даатгалын сангаас авах эрх үүснэ.

Эрүүл мэндийн даатгал нь 1996 оны 1-р сарын 1-нээс эхлэн нийгмийн даатгалын тогтолцоонд багтах болсон бөгөөд одоо нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын дүнд 27.2 хувийг эзлэх болсон байна. Даатгалын санд улсын төсвөөс татаас өгч эхлэв. Төсвөөс олгосон татаас нийт зарлагын дүнд 1995 онд 38.9 хувийг эзэлж байсан бол 1998 онд 28.1 хувь, 1999 онд 30.7 хувь, 2000 онд 27.8 хувь, 2001 онд 25.5 хувь болж буурчээ.

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг хуулинд заасан тодорхой нөхцөл бүхий хүмүүст тэтгэвэр, тэтгэмж олгох, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэхэд зориулдаг. Мөн нийгмийн даатгалын сангаас ажиллагсдын хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн арга хэмжээг санхүүжүүлж байна. Үүгээрээ нийгмийн даатгал нь эдийн засгийн чухал үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Нийгмийн даатгал нь бүхэлдээ хүний хөгжил, амьжиргааны баталгааг хангахад зориулагддагаараа нийгмийн үүрэг гүйцэтгэдэг.

Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн зарлагын өсөлт, бүтэц (сая төг, %)

		1995		2001		1995-2001 харьцуулсан хувь
		Дүн	Хувь	Дүн	Хувь	
Нийт зарлага		24888.4	100	82017.6	100	3.3 дахин
Үүнээс	Тэтгэврийн	17585	70.7	58905.9	71.8	3.3 дахин
	Тэтгэмжийн	855	3.4	2946	3.6	3.4 дахин
	ҮОМШӨ-ний	18.1	-	2241.9	2.7	124 дахин
	Ажилгүйдлийн	-	-	644.3	0.7	
	Эрүүл мэндийн даатгал	6430.3	25.8	15738.3	19.2	2.4 дахин

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангуудын орлого зарлагын 1995-2002 оны тайлан тэнцэл

Даатгалын сангийн нийт зарлага болон дотоод төрлөөрөө 2001 онд 1995 оныхоос 2.4-3.4 дахин өссөн байна. Зарлагын дүнд тэтгэврийн зарлага 71.8 хувь, тэтгэмжийн зарлага 3.6 хувь, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 19.2 хувийг эзэлж байна.

Үндсэн хуулинд болон тэтгэврийн хуулинд зааснаар манай орны иргэд нийгэмдээ 20 ба түүнээс дээш жил хөдөлмөрлөж 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэйчүүд (4 хүүхэд төрүүлж өсгөсөн бол 50 нас) өндөр насны тэтгэвэр авна. Мөн иргэд тодорхой нөхцлөөр тахир дутуугийн ба тэжээгчээ алдсаны тэтгэвэр авна.

Хүснэгт 5. Тэтгэврийн даатгалын сангийн зарлага өсөлт, бүтэц (сая төг, %)

		1995		2001		2001/1995 харьцуулсан хувь
		Дүн	Хувь	Дүн	Хувь	
Нийт зарлага		18822.2	100	59732.7	100	3.2 дахин
Үүнээс	Өндөр насны тэтгэвэр	13900	73.8	41851.5	70.1	3.0 дахин
	Тахир дутуугийн тэтгэвэр	1522.3	8	6212.9	10.4	2.9 дахин
	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	2143.2	11.4	6740.7	11.3	3.1 дахин
	Цэргийн албан хаагчийн тэтгэвэр	19.3	1	3788.5	6.3	196.8 дахин

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлагын 1995-2002 оны тайлан тэнцэл

2001 онд даатгалын сангаас нийт тэтгэвэрт зориулсан хөрөнгө нь 1995 олныхоос 3.2 дахин өссөн байна. Тэтгэвэрт зориулсан хөрөнгөнд өндөр насны тэтгэвэр 70.1 хувь тахир дутуугийн тэтгэвэр 10.4, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 11.3 хувь, цэргийн албан хаагчийн тэтгэвэр 6.3 хувийг тус тус эзэлж байна.

Хүн амын амьжиргааны түвшинг хангах, ядуурлаас хамгаалах зорилгоор сүүлийн жилүүдэд тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлж байна. Тэтгэврийн дундаж

хэмжээг 2000 оны түвшингээс 2 дахин нэмэгдүүлэх зорилт тавьж, 2001 онд тэтгэврийг 8.2 хувиар, 2002 онд 20 хувиар нэмэгдүүлэх арга хэмжээ авч байна.

Үүний үр дүнд тэтгэвэр авагч 266.1 мянган хүн хамрагдав. Тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэхэд илүү анхаарал тавьж байна. Тэтгэврийн доод хэмжээгээр буюу 18850 төгрөг авч байсан 154.8 мянган хүний тэтгэврийг 22600 төгрөг болгож, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээгээр буюу 12375 төгрөг авч байсан 21.4 мянган хүний тэтгэврийг 14860 төгрөг болгож шинэчлэн тогтоолоо.

Даатгалын сангаас нийгмийн халамжийн үйлчилгээгээр 281.8 мянган иргэдэд 17.3 тэрбум төгрөг олгосон байна.

Төр засгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн ба алс ирээдүйн бодлогын нэг гол асуудал нь нийгмийн даатгал, хамгаалал бөгөөд нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгож, нэн ялангуяа тэтгэвэр, халамжийн хангамж хүрэлцээг нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Дэлхийн улс орнуудын олон жил уламжлагдан боловсронгуй болж ирсэн туршлагыг нэлээд нухацтай судалж, өөрийн орны онцлогт зохицсон тогтолцоог сонгох хэрэгтэй юм.

Дэлхийн улс орнуудын туршлагаас үзэхэд тэтгэврийн дараах 3 тогтолцоо хэрэгжиж байна.

- Хуваарилалтын
- Хагас хуримтлалын
- Бүрэн хуримтлалын

Хуваарилалтын тогтолцоо гэдэг нь ажил олгогч, даатгуулагчдын төлсөн шимтгэлийн орлогоос тэтгэвэр авагчдын хөрөнгийг санхүүжүүлж, орлогоороо зарлагаа хагас нөхөх зарчим юм. Дутагдсан хөрөнгийг улсын төсвөөс санхүүжүүлдэг.

Хагас хуримтлалын тогтолцоо гэдэг нь хуваарилалтын болон хуримтлалын аргыг хослуулан хэрэглэж, хуваарилалтын зарчмыг бүрэн хуримтлалын тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлэх үйл явц юм.

Бүрэн хуримтлалын тогтолцоо гэдэг нь даатгуулагчийн тэтгэврийн даатгалын санд насан туршдаа төлсөн шимтгэл нь уг иргэний тэтгэвэрт зориулагдаж, шимтгэлийн хуримтлал нь зөвхөн өөрийгөө бүрэн санхүүжүүлэх зарчмаар ажиллана.

Манай оронд орлого нь зарлагаа нөхөх хуваарилалтын тогтолцоо хэрэгжиж байгаа бөгөөд энэ тогтолцооноос бүрэн хуримтлалын зарчимд шилжихэд макро түвшинд эдийн засгийн үзүүлэлт, мөнгөний ханшны өөрчлөлт тогтворжоогүй, дэд бүтэц, хөрөнгийн зах зээл хөгжөөгүй, найдвартай хөрөнгө оруулалтын орчин бүрдээгүй, банк, санхүүгийн механизм бэхжээгүй шилжилтийн үедээ байгаагаас шалтгаалж ихээхэн хүндрэл бэрхшээлтэй учрах нь тодорхой билээ.

Энэхүү байдлыг харгалзан нийгмийн даатгалын хуваарилалтын тогтолцооноос хагас хуримтлалын тогтолцоонд аажмаар үе шаттайгаар шилжиж

улмаар бүрэн хуримтлалын тогтолцоонд алс хэтдээ шилжих нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл, иргэд хөдөлмөр эрхэлснээс хойш насан туршдаа төлсөн шимтгэлээ тооцож, тэтгэвэр болгон эргүүлж авах зарчмаар бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжих явдал алсын зорилт болон тавигдах болно.

Ажиллагчдын тэтгэврийн орлогыг бүрдүүлэх сонирхлыг татах, улсаас олгох тэтгэврийн тогтолцоог зах зээлийн харилцаанд шилжүүлэх хэрэгсэл нь нэрийн данс нээх арга юм. Хагас хуримтлалын тогтолцоонд шилжих бэлтгэлийг хангах зорилгоор 2001 оноос эхлэн тэтгэврийн даатгалын нэрийн дансны аргыг нэвтрүүлж эхлэв.

Нэрийн данс нь одоогийн хуваарилалтын тогтолцоог хагас хуримтлалын зарчимд алгуур шилжүүлж тэтгэвэрт гарах хүмүүст хагас хуримтлалын зарчмаар тэтгэвэр тогтоох нөхцлийг хангах юм.

Нэрийн дансанд даатгуулагчийн төлсөн бүх шимтгэлийг болон ажил олгогчийн төлсөн шимтгэлийн зохих хэсгийг бүртгэх ба ийнхүү төлсөн шимтгэл нь тухайн хүний нэрийн дансанд хадгалагдаж, бусдын тэтгэвэр, тэтгэмжинд бус, зөвхөн өөрийнх нь тэтгэвэрт эргүүлж олгогдохоор тооцогдох ба дансны мөнгө нь жил, жилийн инфляци ба цалингийн бодит өсөлтийг тооцсон хүүгээр нэмэгдэж, хөрөнгийн үлдэгдлийн тодорхой хувийг засгийн газрын бонд, үнэт цаасны зах зээл, баталгаатай гадаад, дотоодын хөрөнгө оруулалтад оролцуулах, ашигтай ажилладаг компаний хувьцаа, акц худалдаж авах, арилжааны банкинд хөрөнгө хадгалуулж өсгөх, богино хугацаатай зээл олгох зэрэг эдийн засгийн хөгжлийг дэмжих, үнэгүйдлээс хамгаалах найдвартай аргуудыг сонгон хэрэгжүүлэх замаар даатгалын сан, нэрийн дансны хөрөнгийг арвижуулах арга хэмжээ авч байх боломж нээгдэж байгаа юм.

Тэтгэврийн шинэчлэлийн эцсийн зорилго:

- Эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, амьжиргааны түвшинг сайжруулах;
- Өндөр настнуудын хэрэгцээг хамгаалах, өнөөгийн даатгуулагчдыг хожим боломжийн тэтгэврийн орлогоор хангах;
- Хүмүүс өндөр насны тэтгэвэрт гараад төлсөн шимтгэлийнхээ хэмжээгээр тэтгэвэр авдаг шударга тогтолцоо нэвтрүүлэх;
- Баталгаат доод тэтгэвэр олгох болон бүх тэтгэвэр авагчдыг амьдрах хугацааных нь туршид тэтгэврээр хангах замаар нийгмийн хамгааллыг сахин биелүүлэх.

Тэтгэврийн шинэчлэл нь орлогоороо зарлагаа нөхөх зарчмаар тэтгэврийн даатгалын бүтцийг хагас хуримтлалын тогтолцооны бүтэц болгон хувиргана.

Шилжилтийг аажмаар хийх нь хангалттай олон жил ажиллаж тэтгэвэрт хүрэлцэхүйц хэмжээний хуримтлал цуглуулж амжаагүй ахимаг настангуудыг хохироохгүй байх, түүнчлэн хуримтлалын тогтолцоо хэрэгжих нөхцөлд шимтгэлийн орлогын шингээх чадвартай хөрөнгийн зах зээл бий болгох нь нэн чухал ач холбогдолтой болно.

Энэ шинэ тогтолцоонд 1960.01.01 ба түүнээс хойш төрсөн даатгуулагчид хамаарагдана. Харин 1960 оноос өмнө төрсөн хүмүүс хуучин хуульд хамаарагдан тэтгэврийн асуудал нь урдах байдлаараа явагдах болно. Үүнээс гадна тэтгэврийн тогтолцоонд хамрагдахгүй бол яах вэ? гэсэн асуулт бас гарч ирнэ. Энэ тохиолдолд тухайн хүн тэтгэвэр авахгүй. Учир нь нэрийн дансны

аргаар тухайн хүн өөрийн тэтгэвэрт зориулж ямарч хуримтлал хийгээгүй тул тэтгэвэр авахгүй.

Энэхүү шинэчлэл нь:

- Өндөр настан болон тэтгэврийн насанд ойртож яваа хүмүүсийн төлөө санаа тавих;
- Одоо хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс тэтгэвэрт гарах үедээ боломжийн тэтгэвэр авах нөхцлийг бүрдүүлэх;
- Тэтгэврийн даатгалын хөрөнгийн эх үүсвэрийг удаан хугацаанд тогтвортой байлгах;
- Хуваарилалтын шударга зарчмыг баримтлан даатгуулагчидтай адил тэгш харьцах;
- Зах зээлийн эдийн засагт тулгуурласан эдийн засгийн шинэчлэл хийх, хувийн хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, эдийн засгийн хөгжлийг түргэсгэхэд чиглэсэн Засгийн газрын бодлоготой уялдаж байгаа юм.

НОМ ЗҮЙ

1. Д.Ванданмагсар, Ц.Сүхбаатар
“Нийгмийн даатгалын үүсэл хөгжил, шинэчлэл УБ 2002
2. Финансы (ЛА Дробозиной) М.1999
3. Нийгмийн даатгалын тухай багц хууль 1997